

**“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2019.04.26

№ ХЭ-19/01

Улаанбаатар хот

Огноо: 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр

Цаг: 10:00-12:00

Хурал болсон газар: “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК-ийн хурлын танхимд

Хурлын дарга: О.Одбаяр /ТУЗ-ийн гишүүн/

Хурлын нарын бичгийн дарга: Д.Цэцгээ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: 34

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: 92,625,513

Хурлын ирц: 93.01%

Хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
2. “Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэгч гишүүнийг томилох тухай;
3. Компанийн 2017 оны ногдол ашиг тараасан тухай тайлан болон 2018 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны зардлын төсөв батлах тухай;

“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 10:00 цагт “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК-ийн 4 давхрын хурлын танхимд боллоо. Хуралд ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл, гишүүн С.Мөнгөнцэцэг, О.Одбаяр, Аудитын хорооны дарга Д.Балдорж, хараат бус гишүүн Б.Амарсанаа, Халиунбат болон компанийн удирдлагууд хүрэлцэн ирж оролцлоо.

Бүртгэлийг 10:10 цагт хааж, тооллогын комисс ирцийн дүнг нэгтгэн гаргаж, комиссын гишүүн М.Мөнх-Эрдэнэ нийт саналын эрхтэй хувьцааны 93.01 хувийг эзэмшигчид хуралд оролцож, хурлыг хүчин төгөлдөрт тооцсон тухай ирцийн мэдээлэл болон Тооллогын комиссын тогтоолыг танилцууллаа. /Ирцийн дүнг хавсаргав/

Хурлын дарга О.Одбаяр хурлыг нээж үг хэлж, хурлын дэгийг танилцуулснаар хурал эхэллээ. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор хувьцаа эзэмшигчдээс санал гараагүй тул танилцуулгуудыг хийлээ.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ – 1: Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

- “Монгол шуудан” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар нийт хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдэд талархал илэрхийлж, компанийн 2018 оны тайлан танилцууллаа. /Танилцуулгыг хавсаргав/

- Аудитын хорооны дарга Д.Балдорж компанийн 2018 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн Аудитын хорооны дүгнэлтийг танилцууллаа. /Танилцуулгыг хавсаргав/

Хурлын дарга О.Одбаяр: Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцууллаа. Аудитын дүгнэлтээр зөрчилгүй санал дүгнэлт авсан. Нягтлан бодох бүртгэл, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой зэрэг жижиг зөрчлүүдийг цаашид гаргахгүй байх, 2019 оны аудитын дүн дээр дээрх асуудлыг давтан гаргахгүй байхыг гүйцэтгэх удирдлагад анхааруулж, хувьцаа эзэмшигчдийн хурлын протоколд хурал даргалагчийн хувиар тэмдэглүүлж байна.

Өөр санал хүсэлт байхгүй тул дараагийн танилцуулгыг хийлээ.

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Нарангэрэл Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны тайлан болон дүгнэлтийг танилцууллаа. /Танилцуулгыг хавсаргав/

Хурлын дарга О.Одбаяр: Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлантай танилцлаа. Энэ дагуу асуух асуулт байна уу? Миний хувьд өнгөрсөн жил Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажилласан. Анх удаа төр, хувийн хэвшлийн хамтарсан хувьцаат компани үйл ажиллагаагаа сайн явуулж байгаагийн нэг жишээ бол “Монгол шуудан” ХК гэж хэлмээр байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал дээр бид асуудлуудыг нэлээд ширүүн ярилцаж, компанийн бизнесийн хөгжил, бизнесээ өргөжүүлэх, үйл ажиллагаа, үр дүнг өндөр болгох чиглэлээр жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлж, асуудалд нэлээд бодитой хандаж ажилладаг гэдгээ өнөөдөр энд цугласан хувьцаа эзэмшигчиддээ хэлмээр байна. Төр, хувийн хэвшлийн нэлээн сайн хоршил байгаа. Энэ нь санхүүгийн үйл ажиллагааны тайлангийн үзүүлэлт, хувьцааны үнийн тогтвортой байдлаас харагдаж байна. Гүйцэтгэх захирлын танилцуулгад дурдагдсан улс хоорондын логистикийн урсгал сайн хөгжиж байгаа. Оросын шуудангийн байгууллагатай 2019 онд хамтран төсөл хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Ингэснээр компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн үзүүлэлт дээшилж, борлуулалт нэмэгдэхээр ажиглагдаж байгаа. 2019 онд эдийн засгийн хувьд компанид томоохон өөрчлөлт орох болов уу гэсэн хүлээлттэй байгаа. Мөн шинэ нисэх онгоцны буудал ашиглалтад орвол компани шинэ ялган боловсруулах төв барихаар газраа авчихсан, барилга байгууламжаа барихаар төлөвлөөд явж байна. Энэ нь эздийн өмч болон хувьцаа эзэмшигчдэд хөрөнгийг нь нэмэх, компанийн хувьцаанд нөлөөлөх үр дүн бий болохоор байгаа бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн удирдагуудад чиглэл өгч ажиллаж байгаа. Төлөөлөн удирдах зөвлөл дээр болж байгаа үйл ажиллагаа бол компанийн сайн засаглалын хүрээнд эрүүл үйл ажиллагаатай Төлөөлөн удирдах зөвлөл байгаа шүү гэдгийг хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлагатайгаар хэлмээр байна.

Өөр санал хүсэлт байхгүй гэснээр дараагийн хэлэлцэх асуудалд орлоо.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ – 2: *“Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэгч гишүүнийг томилох тухай;*

Хурлын дарга О.Одбаяр: Төрийн төлөөллийг хэрэгжүүлж байсан Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн өөр ажилд шилжсэнтэй холбогдуулаад Засгийн газрын хэрэг эрхлэх газраас өөр нэр дэвшигчийг томилсон.

- Хурлын дарга О.Одбаяр “Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэгч гишүүнд нэр дэвшиж буй Ч.Дондогмааг товч танилцуулгыг хийлээ. /Танилцуулгыг хавсаргав/

Нэр дэвшигчтэй холбоотой санал хүсэлт байхгүй гэснээр дараагийн асуудалд орлоо.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ – 3: Компанийн 2017 оны ногдол ашиг тараасан тухай тайлан болон 2018 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай

ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Халиунбат 2017 оны ногдол ашиг тараасан тухай танилцуулга болон 2018 оны ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцууллаа. /Танилцуулгыг хавсаргав/

Ногдол ашиг тараахтай холбоотой санал хүсэлт байхгүй гэснээр дараагийн асуудалд орлоо.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ – 4: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны зардлын төсөв батлах тухай;

- Хурлын дарга О.Одбаяр Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны зардлын төсвийг танилцууллаа.

Өөр санал хүсэлт байхгүй гэснээр дээрх хэлэлцсэн асуудлуудын санал хураалтын ажиллагаанд орлоо. Санал хураалтын дүн гарч байх хугацаанд 11.10-11:40 цагт цайны завсарлага хийв. Санал хураалтын дүнг нэгтгэж дууссан тул хурлыг 11:40 цагт үргэлжлүүлээ. Тооллогын комиссын дарга Х.Болормаа санал хураалтын дүн болон Тооллогын комиссын тогтоолыг танилцууллаа. /Санал хураалтын дүнг хавсаргав./

Хурлын дэгийн дагуу хурлын дарга О.Одбаяр “Монгол шуудан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолыг танилцууллаа.

Хурлын дарга О.Одбаяр: Нийт хувьцаа эзэмшигч та бүхэндээ “Монгол шуудан” ХК-ийн удирдлагын баг, ажилчдын өмнөөс баярласан талархсанаа илэрхийлж, “Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд хувьцаа эзэмшигчдээ төлөөлөн ажиллаж байгаагийн хувьд хэдэн зүйл хэлье гэж бодож байна. 1-рт: Компанийн хувьцааны үнэ цэнийг унагаж болохгүй, 2019 оны үйл ажиллагаандаа хатуу анхаарч ажиллах ёстой. 2-рт: Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, борлуулалтын төрлийг нэмэгдүүлэх, олон улсын зах зээл дээр өргөн хөгжиж байгаа он-лайн худалдааны хүргэлт болох БНХАУ, ОХУ-ыг холбосон транзит шуудангийн үйлчилгээг эхлүүлж, тодорхой хувийг үйл ажиллагаандаа оруулах ёстой. 3-рт: Санхүүгийн хатуу сахилга батыг баримталж, бизнес төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны зардал, төсөв, тооцоолол зэрэгтэй багтаж ажиллах ёстой. 4-рт: Бизнес төлөвлөгөөгөө төлөвлөхдөө үйл ажиллагааг байнгын хөгжүүлсэн, өргөжүүлсэн, урагшаа харсан, алсыг харсан, “Монгол шуудан” ХК-ийг шуудангийн тэргүүлэх компани болгох чиглэлийг барин ажиллаж, энэ салбартаа тэргүүлэх компани байна гэдэг чигийг баримталж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний хувьд, хувьцаа эзэмшигчийн хувьд, нийт энд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн өмнөөс “Монгол шуудан” ХК-ийн удирдлагад үүрэг болгож энэ хурлын протоколд тэмдэглүүлж байна. Ингээд хуралд ирсэн та бүхэнд баярлалаа. Та бүхэнд аз жаргал сайн сайхан бүхнийг хүсье.

Энэ удаагийн хурал 12:50 минутад өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



О.ОДБАЯР

ДНЭЦГЭЭ